

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН
ХААГЧДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
ХАСАГ ЖИЛЭЭР ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ТАЙЛАН**

2022.06.24

Мандалговь хот

Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Үнэлгээний баг томилох тухай” А/144 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний баг Засгийн газрын 2020 оны 218 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 100 дугаар “Аргачлал, загвар батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэлээ.

Байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэх үнэлгээний багт 6 сарын 20-23-ны өдрүүдэд 26 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээний хуудасны хамт ирснийг журмын дагуу үнэлгээний багийн гишүүд 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдөр хуралдан хэлэлцэн цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөлөө.

Хэлтсүүдийн төрийн захиргааны албан хаагчдын үнэлгээг графикаар
танилцуулбал:

